

Ж.БАТАА: БУРУУ ХҮЛЭЭЛТИЙН УЛМААС ТӨГРӨГИЙН ХАНШ ЧАНГАРАХ

ХАНДЛАГА АЖИГЛАГДЛАА

Оны эхэнд сулраад байсан төгрөгийн ханш дахин чангарч эхэлсэнтэй холбогдуулан Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал Ж.Батаагаас тодруулга авлаа.

Сүүлийн өдрүүдэд ямар шалтгааны улмаас төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарч байна вэ?

-Төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш оны эхнээс 6.5 хувиар, сүүлийн 5 хоногт 1.2 хувиар чангарлаа. Макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг авч үзвэл Монгол Улс гадаад худалдааны алдагдалтай хэвээр байгаа бөгөөд импортын өсөлтийн хурд экспортынхоос 2 дахин илүү байснаар нийт гадаад худалдааны алдагдал оны эхнээс 409.4 сая ам.долларт хүрээд байна. Валютын орох урсгал нь гарах урсгалаас бага байгаагаас валютын цэвэр урсгал оны эхнээс сөрөг, өөрөөр хэлбэл хасах дүнтэй байгаа бөгөөд импортын хэрэгцээ улам өсөн нэмэгдэж байна. Иймд эдгээр хүчин зүйлс ньбогино хугацаанд төгрөгийн ханшулрах нөлөөг үзүүлж байгаа билээ.

Гэвч валютын зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, мөн ханшийн хэлбэлзлийн хандлагын хүлээлтийн улмаас сүүлийн өдрүүдэд төгрөгийн ханш чангарах үзэгдэл ажиглагдаж байна. Заүүнийг тайлбарлах хэд хэдэн хүчин зүйлүүд байна.

Нэгдүгээрт, хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан ноос, ноолуурын орлого орж ирсэнээр төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт. Монгол Улсын гадаад худалдааны өсөлт, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэний улмаас ноос ноолуурын экспортын орлого нь гадаад худалдааны маш багахувийг гээлэхболсон ч иргэдийн дунд ноос, ноолуурын орлогын нөлөөгөөр төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт, хандлага байсаар байна. Хоёрдугаарт, Монгол Улсын Хөгжлийн банк олон улсын зах зээл дээр 580 сая ам.долларын бонд, ММС компани 600 сая ам.долларын бондыг амжилттай арилжаалсан тухай мэдээлэл нь олны дунд төгрөгийн ханш чангарах хүлээлт үүсэхэд нөлөөллөө. Гэвч энэхүү арилжаалсан бондын хэмжээгээр Монголбанк валютын нөөцөө нэмэгдүүлэх тул захад ханшийн савалгаа үүсэхгүй бөгөөд энэхүү бонд нь төмөр зам, авто зам тавих, V цахилгаан станц барих, Сайншандын аж үйлдвэрийн цогцолборыг байгуулах зэрэг ажлуудад зарцуулагдана. Иймээс бондын эх үүсвэрийн дийлэнх хэсэг нь уг төслүүдийн тоног төхөөрөмж, түүхий эд материалд зарцуулагдаж, импортын төлбөрт төлөгдөх замаар буцаад гарна гэсэн үг юм. Сүүлийн нөлөөлсөн хүчин зүйл бол нэр бүхий хэдэн банк бонд гаргахаар яригдаж байгаа бөгөөд энэ нь зах зээлийн хүлээлтийг өөрчлөх замаар нөлөөлж байна. Гэхдээ арилжааны банкуудыг гадаад валютын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахыг Монголбанкнаас журамласан байдаг. Өөрөөр хэлбэл гадаад валютаар барих позиц нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 40 хувиас хэтрэхгүй байх ёстой болохоор бондын арилжаагаар орж ирсэн валютыг хөрвүүлэхгүйгээр барих нөхцлийг хангаж өгч байгаа юм.

Монголбанк төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн чангаралтад ямар байр суурь баримталж байгаа вэ?

-“Валютын ханш макро эдийн засгийн суурь үзүүлэлт, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд үндэслэж уян хатан тогтоно” гэсэн байр суурийг ямар ч үед Монголбанк баримталж ажилладаг. Иймээс валютын ханшийн огцом хэлбэлзэл үүссэн, үүсэх нөхцөл байдал бий болсон үед интервенц хийх замаар валютын захад оролцдог. Жишээ нь, энэ долоо хоногийн эхний дуудлага худалдаагаар банкуудын ам.доллар худалдах саналыг 94.7 хувь, 2 дахь дуудлага худалдаагаар ам.доллар худалдах саналыг 100 хувь биелүүлж, захад оролцлоо.

Иймд дээр дурьдсан шалтгаан, буруу хүлээлтийн улмаас төгрөгийн ханш чангарах хандлага ажиглагдлаа. Монголбанкны зүгээс макро эдийн засгийн суурь үзүүлэлт, ханшийн хэлбэлзэлтэй уялдуулан холбогдох зохицуулалтыг шаардлагатай үед хийсээр байх болно.